

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн
91 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хуулийн этгээдэд Валют солих цэг /цаашид “ВСЦ” гэх/ ажиллуулах, ВСЦ шинээр нэмж байгуулах зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон бусад зохицуулалтын асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. ВСЦ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Монгол Улсын Валютын зохицуулалтын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу зохицуулна.

1.3. ВСЦ-ийн үйл ажиллагаа буюу гадаад валютыг өөрийн нэрийн өмнөөс зөвхөн бэлнээр худалдан авах, худалдах үйлчилгээг Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Монгол улсын хуулийн этгээд эрхэлнэ.

1.4. Валют солих цэг ажиллуулах зөвшөөрөл гэж Хорооноос тухайн хуулийн этгээдэд олгосон ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг хэлнэ.

1.5 Хуулийн этгээд нь хэд хэдэн ВСЦ ажиллуулж болох ба ажиллуулах ВСЦ тус бүр дээр Хорооноос зөвшөөрөл авна.

ХОЁР. ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. ВСЦ ажиллуулах зөвшөөрөлд зөвхөн дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

2.1.1. Өөрийн нэрийн өмнөөс гадаад валютыг бэлнээр худалдан авах, худалдах,

2.1.2. Нэг гадаад валютыг нөгөө гадаад валютаар бэлнээр солих,

2.2 ВСЦ-ийн үйл ажиллагааны аюулгүй байдал, техник тоног төхөөрөмжид дараах шаардлагыг тавина. Үүнд:

2.2.1. Ажилтан, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан харуул, хамгаалалт бүхий байртай байх;

2.2.2. Ажилтны аюулгүй байдлыг хангасан торон /шилэн/ хаалттай байх;

2.2.3. Бичсэн бичлэгийг 1 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын камертай байх;

2.2.4. Тухайн төрлийн валютыг шалгагч болон мөнгө тоологч машинтай эсхүл гадаад валют таних чадвартай боловсон хүчинтэй байх;

2.2.5. Мөнгөн дэвсгэртийг хадгалах шаардлага хангасан сейф, шүүгээтэй байх ё

2.2.6. Бусад шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй байх;

2.3. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийг зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан тогтоож, ханшийн мэдээг нийтэд ил тод мэдээлнэ.

2.4. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь гадаад валютыг худалдан авах, худалдах бүрдээ гадаад валютыг худалдаж авсан, худалдсан тухай баримтыг энэхүү журмын тавдугаар хавсралтын дагуу хоёр хувь үйлдэж, нэг хувийг харилцагчид өгч, нөгөө хувийг санхүүгийн баримт болгон хадгална.

2.5. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээг энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж дараа долоо хоногийн эхний хагаст Монголбанкинд, сар дутмын валют арилжааны тухай мэдээг энэхүү журмын 7 дугаар хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны дотор Хороонд ирүүлж байна.

2.6. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20,000,000 /хорин сая/ төгрөг, түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш үнийн дүнтэй сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанад хүргүүлнэ.

2.7. Хуулийн этгээдийн ажиллуулах ВСЦ тус бүр нь хуулийн этгээдийн оноосон нэрийн ард тоогоор илэрхийлэгдсэн оноосон нэртэй байна.

2.8. Хуулийн этгээд нь ВСЦ-ийн байршил өөрчлөгдөх тухай бүр Хороонд албан ёсоор мэдэгдэнэ.

2.9. Хорооноос ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь ВСЦ шинээр нэмж байгуулахдаа энэхүү журмын дагуу холбогдох материалыг бүрдүүлж ирүүлнэ.

2.10. Хуулийн этгээд нь ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг өөрийн хүсэлтээр хүчингүй болгуулах, зарим ВСЦ-ийг татан буулгах тухай гаргасан шийдвэр, холбогдох баримт материалыг Хороонд ирүүлнэ.

ГУРАВ. ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХАД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. ВСЦ ажиллуулахад дараах үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно. Үүнд:

3.1.1. Гадаад валютыг бэлэн бус хэлбэрээр худалдан авах, худалдах;

3.1.2. Харилцагчдаас гадаад валютыг зээлээр авах, зээлээр худалдах;

3.1.3. Гадаад валютыг өөрийн нэрийн өмнөөс бэлнээр худалдан авах, худалдахаас бусад банкны үйл ажиллагааг эрхлэх;

3.1.4. Үйл ажиллагааныхаа талаар худал, ташаа зар сурталчилгаа, мэдээ, мэдээлэл хийх;

3.1.5. Гадаад валютын ханшийг валютын дэвсгэрийн хэмжээнээс хамааран ялгавартайгаар тогтоох;

3.1.6. Хорооны зөвшөөрөлгүй ВСЦ ажиллуулах, ВСЦ шинээр нэмж байгуулах;

3.1.7. Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдаагүй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг валют солих цэгийн үйл ажиллагаанд ашиглах;

3.1.8. Хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа;

ДӨРӨВ. ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТУУД

4.1. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь Хороонд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.1.1. Энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгохыг хүссэн тухай өргөдөл;

4.1.2. ВСЦ ажиллуулах тухай хуулийн этгээдийн холбогдох тогтоол /Нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагчийн шийдвэр/;

4.1.3. Холбогдох тогтоолоор /шийдвэрээр/ баталсан ВСЦ ажиллуулахтай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн этгээдийн дүрэм, ВСЦ ажиллуулахад мөрдөх журам болон бусад шаардлагатай гэж үзсэн зохицуулалтын баримт бичгүүдийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.1.4. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.1.5. Энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу бичсэн ВСЦ ажиллуулах зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд, түүний хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлагын талаарх тодорхойлолт;

4.1.6. Энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу бичсэн ВСЦ-т ажиллах боловсон хүчний талаарх тодорхойлолт;

4.1.7. Энэхүү журмын 4 дүгээр хавсралтын дагуу бичсэн техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолт, түүнд ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, харуул, хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгаж,

дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээний эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн гэрээний хуулбар;

4.1.8. ВСЦ ажиллуулах хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, ТҮЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажиллах боловсон хүчин нь ял шийтгэлтэй эсэхийг тодорхойлсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

4.1.9. ВСЦ-т ажиллах боловсон хүчин нь валют таних, шалгах болон бусад холбогдох сургалтад хамрагдсан үнэмлэх, гэрчилгээний хуулбар;

4.1.10. Хорооноос шаардсан бусад холбогдох баримт, материалууд;

4.2. ВСЦ ажиллуулахад мөрдөх дотоод журамд ВСЦ-ийн оршин байгаа хаяг, эрх, үүрэг, хүлээх хариуцлага, ажил үүргийн хуваарилалт, тавих хяналт, татан буулгах үндэслэл, буруутай үйл ажиллагаанаас үйлчлүүлэгчдэд учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим болон бусад зохицуулалтын асуудлыг дэлгэрэнгүй тусгана.

4.3. Хороо нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хууль, татвар, аудитын байгууллага болон бусад этгээдээс тухайн хуулийн этгээдтэй холбоотой аливаа асуудлаар нэмэлт тодорхойлолт, лавлагааг гаргуулан авч болно.

ТАВ. ЗӨВШӨӨРӨЛ ХУССЭН БАРИМТ БИЧГИЙГ ХЯНАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

5.1. Хорооны Бичил санхүүгийн газар нь хуулийн этгээдээс ВСЦ ажиллуулах зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг энэхүү журмын дагуу бүрдүүлсэн эсэхийг хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь очиж шалгасны үндсэн дээр тухайн хуулийн этгээдэд ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгох тухай саналаа Хорооны хуралдаанд оруулна.

5.2. Хороо ВСЦ ажиллуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангаж байна гэж үзвэл хуулийн этгээдэд ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг баримт бичгийн бүрдэл гүйцсэн өдрөөс эхлэн ажлын 30 хоногийн дотор гаргана.

5.3. Хорооны тогтоолоор ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдэд Валют солих цэг ажиллуулах зөвшөөрлийн гэрчилгээг 1 жилийн хугацаатай олгоно.

5.4. Хорооны тогтоолоор хууль болон энэхүү журмаар тавигдсан шаардлагыг бүрэн хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулж буй хуулийн этгээдийн Валют солих цэг ажиллуулах зөвшөөрлийн гэрчилгээг 1 жилийн хугацаатайгаар жил бүр сунгана.

5.5. Хороо хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг бүртгэн авч, зохих зааврын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэж, хуулийн этгээдэд ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг олгосон тухайг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

5.6. Орон нутагт хуулийн этгээдээс ВСЦ ажиллуулах зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийн бүрдэлийг тухайн орон нутаг дахь Хорооны төлөөлөгч энэхүү журмын дагуу хянаж, Хороонд ирүүлнэ.

5.7. ВСЦ ажиллуулах зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримт нь энэхүү журмын шаардлагыг хангахгүй, холбогдох хууль тогтоомжийн заалттай зөрчилдөж байгаа болон хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангагүй байна гэж үзвэл зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгохоос татгалзсан тухайгаа Хороо албан ёсоор мэдэгдэнэ.

5.8. Хорооны тогтоолоор ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээд нь ажиллуулах ВСЦ-ийн тоогоор Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр төлнө.

5.9. Хууль болон энэхүү журмаар тавигдсан шаардлагыг бүрэн хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулж буй ВСЦ ажиллуулах зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд ВСЦ шинээр нэмж ажиллуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй гэж үзвэл Хорооны тогтоолоор ВСЦ нэмж шинээр ажиллуулах зөвшөөрөл олгож болно.

ЗУРГАА. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ВСЦ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

6.1. Хороо нь хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

6.1.1. Холбогдох хууль, Хорооноос баталсан энэхүү журмаар тавигдсан шаардлагыг хангагүй, дагаж мөрдөөгүй болон эдгээрийг зөрчсөн нь тогтоогдсон, ирүүлбэл зохих тайлан мэдээг 3 сар дараалан холбогдох байгууллагад /Хороо, Монголбанк/ гаргаж өгөөгүй;

6.1.2. Хорооноос хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй;

6.1.3. Үйлчлүүлэгчдээс удаа дараалан ВСЦ-ийн үйл ажиллагааны талаар гомдол гаргасан, гаргасан гомдол нь үндэслэлтэй нь тогтоогдсон;

6.1.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

6.2. ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн хуулийн этгээд Хорооны тогтоолд заасан хугацаанд хэвийн ажиллах нөхцөлөө бүрдүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан тухайгаа албан бичгээр Хороонд мэдэгдэнэ. Мэдэгдлийн дагуу Хорооны улсын байцаагч газар дээр нь шалгаж, цаашид тухайн хуулийн этгээд ВСЦ ажиллуулж болох эсэхэд дүгнэлт гаргаж, ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг сэргээх эсэхийг удирдлагад танилцуулах ба Хорооны тогтоолоор хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг сэргээнэ.

6.3. Хороо нь хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

6.3.1. Хорооноос ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь дампуурсан, эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

6.3.2. Хорооноос ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь өөрийн хүсэлтээр өөрчлөн байгуулах буюу татан буулгах замаар үйл ажиллагаагаа зогсоо тухай шийдвэр гаргасан;

6.3.3. Зөвшөөрөл авснаас хойш 1 жилийн дотор үйл ажиллагаагаа эхлээгүй;

6.3.4. Холбогдох хууль, Хорооноос баталсан энэхүү журмаар тавигдсан шаардлагыг хангаагүй, дагаж мөрдөөгүй болон эдгээрийг зөрчсөн нь тогтоогдсон;

6.3.5. Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлт гаргаагүй;

6.3.6. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

6.4. Хороо нь хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй болсныг тэмдэглэн, бүртгэлээс хасна.

6.5. Хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай Хорооны тогтоол гарсан өдрөөр ВСЦ-ийн үйл ажиллагааг нь зогсоо ба гадаад валютыг бэлнээр худалдах, худалдан авах, нэг валютыг нөгөө валютаар бэлнээр солих зэрэг үйлдэл хийхийг хориглоно.

6.6. Хороо нь хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

6.7. Хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг Хорооны тогтоолоор хүчингүй болгосон болон хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан өдрөөс хойш 1 жилийн дотор ВСЦ ажиллуулах зөвшөөрөл олгохыг хүссэн тухай өргөдөл, баримт бичгийг тухайн хуулийн этгээдээс Хороо хүлээж авахгүй.

6.8. Хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосноор учирсан хохирлыг Хороо хариуцахгүй.

6.9. Хуулийн этгээдийн ВСЦ ажиллуулах зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай Хорооны тогтоол гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлбэл зөвшөөрөлгүйгээр ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хууль, журамд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

ДОЛОО. ВАЛЮТ СОЛИХ ЦЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

7.1. Хороо нь хуулийн этгээдийн ВСЦ-ийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль, тогтоомж, Хорооноос баталсан заавар, журам хэрхэн мөрдөгдөж байгаад хяналт тавина.

7.2. Шаардлагатай гэж үзвэл Хороо нь төрийн эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран ВСЦ-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж болно.

7.3. Хорооноос ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь ажиллуулж буй ВСЦ-ийн өдөр дутмын үйл ажиллагаанд дараалсан хяналтыг тавьж хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. ВСЦ-ийн үйл ажиллагааг холбогдох хууль, Хорооноос баталсан журам зэргийг зөрчсөнөөс үүдэн гарах хохирлыг ВСЦ ажиллуулж буй хуулийн этгээд хариуцна.

8.2. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, газар дээр шалгалт хийж, хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ**

Огноо:

Хаана: Улаанбаатар-46, Бага тойруу-6, Засгийн газрын IY байр,

Бичил санхүүгийн газар,

Санхүүгийн зохицуулах хороо, Улаанбаатар хот, Монгол Улс

Хэнээс:

(өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

/Хуулийн этгээдийн нэр/

ВСЦ ажиллуулах хуулийн этгээд, түүний удирдлага /хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, ХЗ-ийн дарга, гишүүн, ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч г.м/, ВСЦ-т ажиллах ажилтнуудын талаарх товч мэдээллийг дараах хүснэгтэд нөхөж бичнэ.
Үүнд:

№	Хуулийн этгээдийн нэр	Хаяг	Улсын бүртгэлийн гэрчилгээний	
			дугаар	регистр

Хуулийн этгээдийн удирдлагын талаарх товч мэдээлэл

№	Овог нэр	Эрхэлж буй албан тушаал	Иргэний үнэмлэхийн	
			дугаар	регистр

ВСЦ-т ажиллах боловсон хүчиний талаарх товч мэдээлэл

№	Овог нэр	Одоогийн эрхэлж буй албан тушаал	Иргэний үнэмлэхийн		Эрхлэх албан тушаал
			дугаар	регистр	

Валют солих цэг ажиллуулах зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт материалуудыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Валют солих цэг ажиллуулах журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно.

Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж Валют солих цэг ажиллуулах зөвшөөрлийг олгоно уу.

ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхэлснээс хойшх хугацаанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/тамга, тэмдэг/

/хуулийн этгээдийн нэр/

/албан тушаал/

*/.....
/гарын үсэг/*

*/.....
/овог, нэр/*

**ВАЛЮТ СОЛИХ ЦЭГ АЖИЛЛУУЛАХ
ХҮҮЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД,
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ**

Валют солих цэг ажиллуулах хүүлийн этгээд нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ. Үүнд:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж буй үйл ажиллагааны төрөл:
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой танилцуулга /эрхэлжсэн үйл ажиллагааг хугацаагаар нь, хараат буюу охин компанийтай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр зэргийг хамруулан бичнэ/ :
- ВСЦ-ийн үйл ажиллагаанд ашиглах мөнгөн хөрөнгийн танилцуулга, тодорхойлолт

Хуулийн этгээдийн нэр _____ нь ВСЦ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа / _____ тоогоор _____ / / _____ усгээр _____ / төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн Хороонд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцаахаа илэрхийлж байна.

Валют солих цэг ажиллуулах хуулийн этгээдийн хувь нийүүлэгч, гүйцэтгэх удирдлага нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

Хуулийн этгээдтэй ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

1. Үүсгэн байгуулагч
2. Нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч
3. ТУЗ-ийн дарга
4. ТУЗ-ийн гишүүн
5. ХЗ-ийн дарга
6. ХЗ-ийн гишүүн
7. Гүйцэтгэх захирал
8. Нягтлан бодогч

- овог, нэр:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьялал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

- товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний уйл ажиллагаа, байршил, банк, ББСБ-тай харьцааж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

Холбогдох этгээдийн байдал: /Холбогдох этгээд гэдгийг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсноор ойлгоно/

№	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байришил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Гүйцэтгэх удирдлага боловсон хүчиний талаарх хууль хяналт, татвар, аудит, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагaa зэргийг хавсаргав.

/хуулийн этгээдийн нэр/

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

"*Валют солих цэг ажиллуулах журам*"-ын
гуравдугаар хавсралт

ВАЛЮТ СОЛИХ ЦЭГИЙН УДИРДЛАГА, БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

ВСЦ-ийн удирдлага, боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- овог, нэр:
- эрхлэх албан тушаал:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьялал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар /*Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

- гүйцэтгэх удирдлага, боловсон хүчиний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний уйл ажиллагаа, байршил, банк, ББСБ-тай харьцааж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

Холбогдох этгээдийн байдал: /Холбогдох этгээд гэдгийг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсноор ойлгоно/

№	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

Холбогдох этгээдийн товч таницуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний уйл ажиллагаа, байршил, бусад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, аудит, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргав.

/хуулийн этгээдийн нэр/

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

ВСЦ-ийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

№	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн алиin болох	Тоо ширхэг

ВСЦ нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна нягтлан бодох бүртгэлийн (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон -г (худалдан авсан, худалдан авах гэж байгаа эсхүл гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

ВСЦ нь үйл ажиллагаа явуулах байрыг:

- худалдан авсан
түрээслэсэн

бөгөөд энэхүү байр нь ВСЦ-ийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

- Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ
Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ
Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн
талаар тайлбар

/хуулийн этгээдийн нэр/

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

"*Валют солих цэг ажиллуулах журам*"-ын
тавдугаар хавсралт

ГАДААД ВАЛЮТ ХУДАЛДАЖ АВСАН/ ХУДАЛДАХ ТУХАЙ БАРИМТ

Валют солих цэгийн нэр _____

Он / cap / өдөр _____

Худалдаж авсан/ худалдсан валютын нэр _____ Ханш _____

Валютын дүн _____
(*тоогоор*)

(*Үсгээр*)

Төгрөгийн дүн _____
(*тоогоор*)

(*Үсгээр*)

ВСЦ-ийн ажилтны албан тушаал: _____

Овог нэр: _____

Гарын үсэг: _____

/Тамга/

"*Валют солих цэг ажиллуулах журам*"-ын
зургаадугаар хавсралт

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ /долоо хоногоор/

.....сарын.....өдрөөссарынөдрийн валютын арилжааны мэдээ
/Байгууллагын нэр/

Д/д	Өдөр	ААН, хувь хүн аль нь болох	Валют/ тус бүрээр/	Ханш	Дүн		Зориулалт
					авсан	зарсан	

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/

"*Валют солих цэг ажиллуулах журам*"-ын
долоодугаар хавсралт

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ /сараар/

200... оны ...-р сарын ... өдөр

Валют солих цэгийн нэр:					Утас:	Факс:
№	Худалдаж авсан	Валютын төрөл / <i>тус бүрээр</i> /	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдээс					
2	Иргээс					
	ДҮН					
	Дундаж ханш					
№	Худалдсан	Валютын төрөл / <i>тус бүрээр</i> /	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдэд					
2	Иргэнд					
	ДҮН					
	Дундаж ханш					

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал

Овог нэр

Гарын үсэг.....

/тамга/